

## ОЙЛГОХУЙ БА ТАЙЛБАРЛАХУЙН ХАРИЦААНЫ ТУХАЙ ГЕРМЕНЕВТИКИЙН АСУУДАЛ

*Г.Лодой /зөвлөх профессор, доктор (Ph.D)/  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим  
В.И. Павлов /доктор (Ph.D)/  
МУИС, Европ судлалын тэнхим*

**Түлхүүр үгс:** ойлгохуй, тайлбарлахуй, герменевтикийн эргүүлэг, хэрэглэхүй, хэл ба ойлгохуйн харилцаа, эдүгээ үйлчлэх түүх, герменевтикийн гурвалжин.

**Товч утга:** Философийн герменевтикийг Х.Г.Гадамер “Үнэн ба арга. Философийн герменевтикийн үндэс” хэмээх зохиолдоо анх хэрэглэжээ. Түүний өмнөх үеийнхэн энэ асуудалд хүмүүнлэгийн ухааны ерөнхий онол, арга зүй талаас нь голлон анхаарч байсан бол Х.Г.Гадамер энэ хандлагад шүүмжлэлтэй хандаж байсан ба философи сэтгэлгээний оновчтой хэлбэр бол герменевтик буюу ойлгохуйн ухаан байх ёстой гэдэг санааг бүх талаар үндэслэхийг оролдож байжээ.

Г.Гадамерын үзэж байгаагаар, хэл бол хүн ертөнц хоёрыг нэгтгэн холбогч орчин бөгөөд тэрээр ойлгохуйн оногдохуй болж байдаг ахуй нь болдог юм. Хүн ертөнцийн харилцаа нь хэлний хүчин зүйлсээр нөхцөлдсөн байдаг учир ойлгох боломжтой байдаг хэмээн тэрбээр үздэг ажээ.

Мэдээлэл солилцох, түүнийг ойлгох, тайлбарлах, хэрэглэх явдал танин мэдэхүй болон практик үйл ажиллагааны зайлшгүй нөхцөл, гол хүчин зүйлсийн нэг байдаг. Нийгмийн амьдралд мэдээллийн үүрэг улам өсөн нэмэгдэж буй орчин үед өрнө дахины философи сэтгэлгээний тэргүүлэх чиглэлийн нэгэнд тооцогдож буй сургаал бол философийн герменевтик юм.

Эх бичгийг тайлбарлах онол, практикийн тухай сургаалыг герменевтик хэмээн их төлөв нэрлэдэг билээ. Энэ утгаар герменевтик нь бичиг үсэг үүссэн тэр цаг үеэс эхлэлтэй гэж хэлж болно. Харин философийн герменевтик бол XIX зууны үеэс биеэ даасан салбар ухааны хэлбэрээр өрнө дахинд үүсч хөгжсөн сургаал юм.

Философийн герменевтикийг

үндэслэгч нь хэн бэ? гэдэг асуудалд нэгэн утгатай хариу өгөхөд нэн бэрхшээлтэй боловч уг нэр томъёог анх хэрэглэсэн хүн бол германы философич Х.Г.Гадамер билээ. Тэрбээр өөрийн гол бүтээл болох “Үнэн ба арга. Философийн герменевтикийн үндэс” хэмээх зохиолдоо герменевтик сургаалын тэргүүлэх чиглэлүүдийг шүүмжлэлтэйгээр авч үзэж философи сэтгэлгээний оновчтой хэлбэр бол герменевтик буюу ойлгохуйн ухаан байх ёстой гэдэг санааг олон талаас үндэслэхийг оролдсон байдаг ба философийн ухаан өөрөө герменевтикийн шинжтэй гэдгийг нотлохыг зорьдог байжээ. Харин Г.Гадамерийн өмнөх үеийнхэн герменевтикийг хүмүүнлэгийн ухааны ерөнхий онол, арга зүй болох талаас нь голлон анхаардаг байжээ.

### **1. Философийн герменевтикийн үндсэн асуудал**

Түүхийн сурвалж бичиг, шашны ном зохиол, хууль эрхийн баримт бичиг, урлаг уран зохиолын бүтээлүүдийг тайлбарлах, ойлгох, утга тайлал хийх зэрэг асуудал герменевтикийн гол судлагдахуун болж байжээ. Эдгээр асуудалтай холбоотой герменевтикийн салбар ухааны хүрээнд аливаа бичвэр материалыг тайлбарлах янз бүрийн арга техникийг боловсруулж байв. XIX зууны үеэс ойлгохуйн үйл явцын ерөнхий зарчим, зүй тогтолыг олж тогтоох асуудал герменевтикийн гол зорилт болсон төдийгүй герменевтикийн ерөнхий онолыг боловсруулах анхны алхамуудыг хийж эхэлжээ. Эл асуудлыг шийдвэрлэх зорилт тавьсан хүний нэг бол германы философич Ф. Шлейермахер юм. Ойлгохуйн үйл явц бол хүний амьдралын нийтлэг үзэгдэл болох тул ойлгохуйн ухаан болох герменевтикийн ерөнхий онол байх ёстой гэж тэрбээр үзэж байв.

Герменевтикийн ерөнхий онолыг боловсруулах зорилт дэвшүүлэхдээ Ф.Шлейермахер юуны өмнө ойлгохуйн аливаа хэлбэрийн зайлшгүй анхдагч нөхцөл юунд орших вэ? гэдэг асуултанд хариулт өгөхийг оролдсон байна. Түүний үзлээр, харилцагч субъектуудын, өөрөөр хэлбэл, зохиогч ба уншигч, харилцан ярилцагч хоёр этгээдийн нийтлэг болон ялгаатай тал нь ойлгохуйн үндэс болох ёстой ажээ /3.63/. Энэ хоёрын аль нэг нь байхгүй бол ойлгохуйн үйл явц боломжгүй гэж тэрбээр үздэг.

Харилцагч субъектуудын нийтлэг болон ялгаатай талууд нь ойлгохуйн зайлшгүй нөхцөл болдог бол түүнийг

хэрэгжүүлэх орчин нь хэл юм гэж Шлейермахер үзэж байв. Шлейермахерын дэвшүүлсэн энэ санаа орчин үеийн философийн герменевтикийн тулгуур баримтлал болдог. “Хүмүүс бие биенээ ойлгох үйл явдал төдийгүй ойлгохуйн үйл явц бүхэлдээ хэлний үзэгдэл байдаг” /2.44/ хэмээн орчин үеийн философийн герменевтикийн гол төлөөлөгч Г.Гадамер онцлон тэмдэглэсэн байдаг.

Хэл сэтгэхүйн харилцаа холбоо, хэлний үүсэл хөгжлийн зүй тогтолын асуудал бол философийн тулгуур асуудлын нэг билээ. Эл асуудлыг их төлөв танин мэдэхүйн асуудлуудтай холбоотойгоор авч үзэж байсан уламжлалаас философийн герменевтикийн ялгагдах онцлог нь ойлгохуйн үйл явцыг хүний үйл ажиллагааны бүх хүрээг хамрах үзэгдэл хэмээн үзэж хүний сэтгэхүйн үйл явц нь ойлгохуйн талыг өөртөө ямагт агуулахын сацуу хэлний хүчин зүйлсээс хамааралтай явагдана гэж үздэгт оршино. “Хэл бол ойлгохуйн үйл явц явагдах универсаль орчин мөн. Эл үйл явцыг хэрэгжүүлэх арга нь тайлбарлахуй болно... Иймд ойлгохуйн үзэгдэл бол хэл яриа ба сэтгэхүйн харилцааны онцгой тохиолдол болдог” /1.452/ гэж Г. Гадамер бичсэн байдаг.

Философийн герменевтикийн гол зорилт нь шинжлэх ухааны баримтыг үнэний шалгуур болгодог өрөөсгөл хандлагыг даван туулж үнэнд хүрэх нөхцөлийг тодорхойлоход оршино хэмээн Г.Гадамер үздэг. Тэрбээр бичихдээ: “Герменевтикийн сэтгэлгээний тусламжтайгаар судалгааны логикд үл агуулагдах түүний угтвар болох үнэнд хүрэх нөхцөлийг олж тогтоовол

герменевтик нь шинжлэх ухааны онолд зохих байр сууриа эзэлнэ” /1.616/ гэжээ.

Энэхүү нөхцөл нь үнэнд хүрэх сэтгэхүйн үйл явцад өөрт нь агуулагдана хэмээн И. Кант үзэж байсан бол Г. Гадамер үнэнд хүрэх нөхцөл нь хэлний уламжлалаас шууд хамааралтай хэмээн үздэг.

Г. Гадамерын үзлээр хэл бол хүн ертөнц хоёрыг нэгтгэн холбогч орчин бөгөөд ойлгохуйн оногдохуй болж байдаг ахуй бол хэл юм. Хүн ертөнцийн харилцаа нь хэлний хүчин зүйлсээр нөхцөлдсөн байдаг учир ойлгох боломжтой байдаг хэмээн тэрбээр үздэг /1.448-450/.

Герменевтик нь ертөнц, бодит байдлыг объект субъектын харилцаанаас тайлбарлахыг оролдож ирсэн философийн уламжлалыг эвдэж хүн ертөнц хоёрын холбогчийн үүргийг гүйцэтгэгч хэлний орчин, түүнийг танин мэдэх хэлбэр болох ойлгохуйн үйл явц хоёрын харилцаанд тулгуурлан бодит байдлыг тайлбарлахыг өөрийн үндсэн асуудлаа болгодог.

## **2. Ойлгохуйн үйл явцын бүтэц, арга хэлбэр**

Ойлгохуйн үйл явцын ерөнхий зүй тогтол, дүрэм, зарчмуудыг тодорхойлох зорилтыг Ф. Шлейермахер анхдэвшүүлжээ. Хүний амьдрал үйл ажиллагааны нийтлэг үзэгдэл болохын хувьд ойлгохуй нь гурван үе шаттай байна хэмээн тэрбээр үзэж байв /3.67/. Эхний буюу доод шатанд ойлгохуйн үйл явц нь ухамсарлагдсан бус байдалтай, механик шинжтэй байдаг бол хоёр дахь шат буюу герменевтикийн тусгай онолын төвшинд тодорхой хэмжээний туршлагыг нэгтгэн дүгнэсний үр дүнд бий болсон дүрэм горимын дагуу явагддаг ажээ.

Зөвхөн дээд шат буюу ерөнхий онолын төвшинд ойлгохуйн үйл явц нь сэтгэхүйн урлагийн шинж төрхийг олдог байна.

Герменевтикийн ерөнхий онол нь ойлгохуйн урлаг болохын хувьд ойлгохуйн үйл явцын бүх тохиолдолд хэрэглэгдэх ерөнхий дүрэм, зарчмуудтай байх ёстой гэж Шлейермахер үзээд тэдгээрийг тодорхойлох зорилт тавьсан байна. Ойлгохуйн урлаг нь хэл, сэтгэхүйн мөн чанараас сурвалжтай зарчмуудын цогц систем байх төдийгүй унших, бичих, сэтгэхэд сургаж болдог шиг түүнд суралцаж болно хэмээн тэрбээр үзэж байжээ. Герменевтикийн ерөнхий онолын үндсэн зарчмын нэг нь “герменевтикийн эргүүлэг” юм. Аливаа ойлгохуйн үйл явц нь бүхэл хэсгийн харилцан шүтэлцээнд тулгуурлах бөгөөд хэсэгчилсэн ойлгоцоос нэгдмэл цогц ойлгоцонд хүрэхийн тулд хэсгийг бүхлээс нь тайлбарлах шаардлагатай гэж герменевтикийн онол үздэг. Бүхлийг хэсгээс хэсгийг бүхлээс ойлгох хэрэгтэй гэсэн санааг “герменевтикий эргүүлэг”-ийн зарчим гэдэг.

Эл шаардлагыг биелүүлэхэд дивинац -ийн ба харьцуулан жиших аргуудыг хослуулан хэрэглэх хэрэгтэй гэж Шлейермахер үзсэн байдаг. Дивинацийн арга гэдэг нь бүхлийг интуицийн тусламжтайгаар урьдчилан ойлгохыг хэлдэг. Энэхүү урьдач ойлголцооны хэсгүүдийг харьцуулан жиших замаар баталгаажуулан нарийвчлаж, улмаар засварлах үндсэн дээр бүхлийн тухай илүү оновчтой шинэ ойлгоцонд хүрч, түүнийгээ дахин харьцуулан судлах гэх мэтийн шатлалыг “герменевтикийн эргүүлэг” хэмээн томъёолсон байдаг /3.72/.

Ойлгохуйн үйл явцад энэ шаардлагыг хэрэгжүүлэх зайлшгүй нөхцөл нь судлаач ба судалж буй зүйлийн зохиогч хоёрын ялгааг арилгаж нэг төвшинд оруулах явдал мөн. Үүний тулд, судлаач өөрийгөө судалбар болж буй зүйлийн зохиогчийн / өгүүлэгчийн/ байранд тавих ёстой хэмээн Ф. Шлейермахер үзэж байв. Өөрөөр хэлбэл, судлаач ба зохиогч хоёрын хоорондын түүхэн зааг ялгааг арилгах ёстой ажээ.

Ф.Шлейермахерын дэвшүүлсэн энэ санааг Г.Гадамер шүүмжилж бичихдээ. “Цаг хугацааны зааг ялгааг арилгах хэрэггүй юм. Түүхэн байрсууринаас хандах гэдэг гэнэн баримталлын улмаас хүмүүс тухайн цаг үеийн байдалд өөрсдийгөө шилжүүлж өөрийнхөө ойлголт төсөөллөөр бус тэр үеийн ойлголт төсөөллөөр сэтгэж түүхийн объектив ойлгоцонд хүрэхийг оролддог” /2.80/ гэжээ. Судлаач зохиогч хоёрыг зааглаж буй цаг хугацааны ялгаа нь ойлгохуйн үйл явцад саад болох бус харин үнэн зөв ойлгоцонд хүрэх боломжийг бүрдүүлдэг гэж Г. Гадамер үзсэн байдаг.

Г.Гадамерийн үзлээр ойлгохуйн үйл явцын зорилго нь түүхэн бодит байдлыг өөрийн ертөнц болгож харах замаар түүний утга учир, ач холбогдлыг ухаарах явдал юм. Түүхийг ойлгоно гэдэг нь урьд өмнө болж өнгөрсөн үйл явдлуудыг сэргээн төсөөлөхөд бус, харин тэдгээрийг өөрийн ухамсрын ертөнцийн шүүлтүүрээр дамжуулан идэвхитэй шүүн тунгаахыг хэлэх ажээ. “Түүхийн ухамсар нь өөрийн түүхийг ухамсарлах үндсэн дээр өөрийгөө ойлгодог. Түүхийн ухамсар бол өөрийгөө танин мэдэх арга мөн” /1. 285/ гэж Г. Гадамер онцлон тэмдэглэсэн байдаг. Ойлгохуйн үйл явц нь түүх ба түүхийн

тухай мэдлэг, түүхийн шинжлэх ухаан ба уламжлалын хоорондахь эсрэг тэсрэг байдлыг даван туулахад чиглэх ёстой гэж философийн герменевтик үздэг. Түүхийн ухамсар нь судлагдахуунаасаа өөрийнхөө өнгөрсөн түүх ба одоог нэгдэлд нь олж харж ойлгох ёстой бөгөөд энэхүү нэгдлийг нөхцөлдүүлэгч нь “эдүүгээ үйлчлэгч түүх” /2.82/ буюу уламжлал ажээ.

Гадамерийн үзлээр ойлгохуйн үйл явц бүхэл, хэсгийн хоорондын “эргүүлэг” маягийн бүтэцтэй болох нь маргаангүй боловч энэхүү тэрээр ойлгохуйн үйл явцын өөрийнх нь онтологийн бүтцийн илрэл нь ажээ. “Герменевтикийн эргүүлэг” нь “уламжлал ба тайлбарлалын харилцан үйлчилгээг илэрхийлдэг” /1.348/ юм.

Үүнтэй холбоотойгоор герменевтикийн уламжлалд баримталсаар ирсэн үндсэн зарчмуудын нэг болох “зохиогчийг өөрөөс нь илүү ойлгох” ёстой гэсэн зарчмыг өөрөөр томъёолох хэрэгтэй гэсэн санааг Г.Гадамер дэвшүүлсэн байдаг. Судалбар болж буй зүйлийн зохиогчийг өөрөөс нь илүү ойлгох нь гол бус, харин түүнийг одоо цагийн нөхцөл байдлын үүднээс харж өөрөөр ойлгох нь чухал /1.350-351/ гэжээ.

Эдүгээчлэн ойлгох гэдэг нь өөрийн субъектив байр сууринаас хандахыг судлаачдаас шаардаж буй хэрэг огтхон ч биш бөгөөд өнгөрсөн ба одоогийн харилцан шүтэлцээнээс цоо шинэ утга санаа, учир холбогдлыг олж харна гэсэн үг билээ. Ойлгохуйн оногдохуй болж буй зүйлийг одоогийн нөхцөлд хэрэглэх замаар түүний утга холбогдлыг баяжуулан ойлгохыг эдүгээчлэн ойлгох гэж хэлнэ.

Герменевтикийн аливаа үйлдэл нь ойлгохуй - тайлбарлахуй - хэрэглэхүй гэсэн гурвал интеграл бүтэцтэй байна гэсэн үзэл санаа бол Г.Гадамерийн концепцийн шинэлэг тал нь юм. Ойлгохуй бол судлагдахуун болгон авсан зүйлээ объектив байдлаар нь танин мэдсэний үр дүнд бус, харин өөрөө байнга өөрчлөгдөж байдаг үйл явц мөн /1.366-367/ гэсэн санаа эл баримтлалын гол цөм нь болдог.

Шинжлэх ухааны мэдлэг эзэмшдэг шиг ямар нэгэн зүйлийн тухай ойлгоцыг хүнд эзэмшүүлж болохгүй бөгөөд ойлгохуй бол субъектын өөрийн нь үйл ажиллагаа, үзэл баримтлал, зорилго, түүхэн уламжлал, хэлний орчин зэрэг олон хүчин зүйлийн огтолзол дээр үүсдэг бүтээлч үйл явц байдаг. Энэ утгаараа ойлгохуй нь ёс суртахууны мэдлэг төлөвшдөг үйл явцтай төсөөтэй зүйл гэж Г. Гадамер үзсэн байдаг /1.369-382/.

Ойлгохуйн үйл явцын гурвал маягийн бүтцэнд хэрэглэхүйн үүрэг нэн чухал болохыг тайлбарлахдаа: “Ёс суртахууны мэдлэгийг тайлбарласан Аристотелийн задлан шинжлэл нь герменевтикийн зорилгыг тодорхойлж буй тэрхүү асуудлын өвөрмөц маягийн загвар юм. Хэрэглэхүй бол ойлгохуйн үйл явцын гүйцээлт болдог, заавал байх албагүй хэсэг бус, харин түүнийг бүр эхнээс нь бүх талаар нь тодорхойлдог зүйл мөн” /1.382/ гэжээ. Ойлгохуй бол “түүхийг идэвхитэй ухамсарлах” үйл явц мөн гэсэн санааг тайлбарлах гол түлхүүр нь “хэрэглэхүй” хэмээх ойлголт болдог байна.

Г.Гадамер “хэрэглэхүй” хэмээх ойлголтыг ойлгохуйн үйл явцын танин мэдэхүйн бүтцийн асуудалтай

холбоотойгоор нарийвчлан тайлбарласан байдаг. Ойлгохуйн үйл явц нь харилцан ярилцлагын хэлбэртэй асуулт-хариултын бүтэцтэй байна гэсэн үндэслэл бол Г.Гадамерын философийн герменевтикийн бас нэг шинэлэг тал нь юм. Аливаа бичвэр материалыг тайлбарлана гэдэг бол түүнд авч үзэж буй асуултанд хариулна гэсэн үг юм. Уг материалыг ойлгоно гэдэг нь тухайн асуултыг ойлгож буй хэрэг мөн гэж тэрбээр үзсэн байдаг.

Харилцан ярилцлагын явцад өөрийн болон бусдын үзэл санааны эсрэг тэсрэг байдлыг арилгаж аль алиныг өөртөө агуулсан тийм нийтлэг зүйлд хүрэх нь ойлгохуйн зорилго болдог. Ойлгохуйн харилцаанд оршиж буй субъектуудын түүхэн зааг ялгаа нь судлаачийн өөрийнх нь урьдач төсөөлөл, судлагдахуун болж буй зүйлийн утга агуулгын алдаа оноог шүүн тунгаах боломжийг олгодог байна. Энэ утгаараа ойлгохуйн асуулт-хариултын бүтэц нь түүний бүтээлч шинж чанарын илэрхийлэл болдог ажээ. Энэ тухай Г.Гадамер бичихдээ: “Герменевтикийн туршлагын бүтцэд бидний нээн илрүүлсэн асуулт-хариултын диалектик нь “түүхийг идэвхтэй ухамсарлах” гэж юу вэ? гэдгийг оновчтой тодорхойлох боломжийг олгоно. Бидний өгүүлж буй асуулт хариултын диалектик нь ойлгохуй ба түүний судлагдахуун хоёрын хоорондын харилцаа нь ярилцлагын үед үүсдэг нөхцөлтэй төсөөтэй болохыг харуулж байна” /1.443/ гэжээ.

Ойлгохуй-тайлбарлахуй-хэрэглэхүй гэсэн герменевтикийн үйлдлийн интеграл бүтэц, асуулт хариултын диалектик, түүхийг идэвхтэй ойлгох зэрэг ойлголтууд

нь “герменевтикийн гурвалжин” /3.47-48/ хэмээх тогтолцооны дотоод механизмыг тайлбарлахад зориулагдсан байдаг. Герменевтикийн гурвалжны ерөнхий бүдүүвчийг дараах байдлаар томъёолж болох юм. Герменевтикийн нөхцөлд оршиж буй хоёр субъектийг холбогч нь бичвэр судлагдахуун бөгөөд түүнийг зохиогч өөрийн хэлний орчинд буулгасныг судлаач өөрийн хэлний орчинд утга тайлал хийж тайлбарласны үр дүнд зохиогчийг ойлгодог гэсэн санааг герменевтикийн гурвалжин гэдэг. Үүний гол утга нь бичвэр судлагдахуунаар дамжуулж түүний зохиогчийг ойлгох бус, харин бичвэр судлагдахууны утга санааг судлаач өөрийн ухамсарын санд буулгаж хэрэглэснээр зохиогчийн санааг ойлгоход оршдог. Энэ зорилгыг биелүүлэх гол хэрэглүүр нь асуулт-хариултын хэлбэр буюу ярилцлага, хэрэглэхүй, тайлбарлахуйн үйлдлүүд байдаг.

Хувь хүний үзэл баримтлалаас үл хамаарах объектив ойлгоц гэж огт байхгүй учир шинжлэх ухааны судалгааны аргууд нь үнэнийг бүх талаас нь баталгаажуулж чадахгүй юм. Иймд үнэнд хүрэх арга хэрэглүүр зөв байхын зэрэгцээ үнэнд хүрэх нөхцөлийг зөв тодорхойлох хэрэгтэй. Энэхүү зорилгыг биелүүлэхэд философийн герменевтикийн гол үүрэг сршино /1.568/ гэсэн санааг бүх талаас нь үндэслэхэд Г. Гадамер өөрийн гол бүтээл “Үнэн ба арга. Философийн герменевтикийн үндэс” гэдэг зохиолоо зориулсан байдаг.

### **3. Философийн мэдлэгийн тухай герменевтикийн үзэл баримтлал**

Философийн мэдлэгийн онцлог, судлагдахуун, үүргийн тухай асуудал

бол философи сэтгэлгээний бүх түүхийн туршид тулгуур асуудлын нэг байсан бөгөөд эдүүгээ хүртэл нэгэн утгатайгаар шийдээгүй байна. Философийн сургаал бүхэн эл асуудлыг өөрийнхөөрөө тайлбарлаж ирсэн билээ.

Философи гэж юу вэ? гэдэг асуултанд янз бүрээр хариулж болох боловч ямар ч хариулт байлаа гэсэн философи бол ойлголтуудын тусламжтай бодит байдлын ерөнхий зураглалыг гаргадаг ухаан гэсэн санаа заавал агуулагдаж байдаг. “Философийн судлагдахуун бол ойлголт мөн гэсэн хариултыг Аристотелээс Гегель хүртэл баримталсаар ирсэн уламжлалтай билээ” /2.27/ гэж Г. Гадамер тэмдэглээд эдүүгээгийн шинжлэх ухааны эрин үед философийн судлагдахуун хэвээр үлдсэн үү? гэдэг асуултыг дэвшүүлж тавьсан байдаг.

Г.Гадамерын үзлээр, “шинжлэх ухаан танин мэдэхүйн цорын ганц хэлбэр болохоо харуулахыг эрмэлзэж буй эдүгээ үед түүний тухай онол, логик, мөн түүнчлэн хэлний шинжлэл философийн тэргүүн эгнээнд гарч иржээ. Энэ хандлага улам газар авч байгаагийн улмаас тэдгээрээс бусад бүх зүйлийг ертөнцийг үзэх үзэл буюу үзэл суртал хэмээн үзэж философийн шинжлэх ухаанаас хасахад хүрч байгаа /2.29/ ажээ.

Ийм тохиолдолд шинжлэх ухаантай мөр зэрэгцэн оршиж чадах зүйл философид үлдэх үү? гэдэг асуудал гарч ирнэ. Эл асуултыг жирийн хүнд тавибал “ертөнцийг үзэх үзэл, үзэл суртлын хуурамч, хялбархан үеэ өнгөрөөдөг төөрөгдлийн эсрэг шинжлэх ухааны философи ойлголтыг хоёрдмол утгагүйгээр тодорхойлох ёстой” гэж хариулна хэмээн Г.Гадамер тэмдэглээд

“манай зууны эхэн үед хоёрдмол утгагүй ойлголтын хэлийг бүтээхийг философийн логик гол зорилгоо болгож шургуу тэмцэж байсан боловч хэрэгжих боломжгүй болох нь харагдсан билээ /2.29/ гэжээ.

XX зууны эхэн үед үүсч хөгжсөн неопозитивизмын сургаалд философийн гол судлагдахуун бол шинжлэх ухааны хэлэнд шинжилгээ хийх явдал мөн гэдэг санааг дэвшүүлж философи сэтгэлгээний түүхийг энэ байр сууринаас хянаж үзэхийг оролдож байсан билээ. Неопозитивизмын дэвшүүлсэн энэ үзэл баримтлал өрнө дахины философи сэтгэлгээнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн төдийгүй эдүгээ хүртэл уг уламжлал хадгалагдсаар байна.

Неопозитивизмын сургаалаас философийн герменевтикийн ялгагдах тал нь танин мэдэхүйд ердийн хэлний гүйцэтгэх үүргийг онцгойлж үздэгт оршино. Хэл бол ертөнцийг бүхэлд нь урьдчилан тайбарлахуй мөн учир юугаар ч сольж болшгүй зүйл юм. Ойлголтууд үүсэх үйл явц нь хэлний орчинд явагддаг учир цоо шинээр бий болдог бус, харин хэлний орчинд үүсч төлөвшсөн сэтгэлгээний үргэлжлэл болно /2.29-30/ гэж Г.Гадамер үздэг. Иймд уг ба ойлголтын харилцан холбоо шүтэлцээг авч үзэх нь философийн эн тэргүүний зорилт байх ёстой ажээ.

Философийн ухаанд ямар нэгэн асуудлыг нэгэн утгатай төгс шийдвэрлэх боломжгүй гэдэг нь маргаангүй зүйл билээ. Философийн аливаа асуудал нь тухайн цаг үе түүхэн бодит байдлаас сурвалжтай үүсч, тухайн үеийнхээ сэтгэлгээний цар хэмжээнд шийдвэрлэгддэг ёстой. Тухайлбал, чөлөөт байдал гэж юу вэ? гэдэг асуултыг ерөнхий байдлаар авч үзэж

шийдвэрлэх боломжгүй юм. Түүхэн эрин үе бүхэнд чөлөөт байдлын асуудал тавигдаж байсан хэдий боловч тухайн үе бүхэнд өөр өөр утга агуулгатай байсан билээ. Ийм эрэгцүүлэлийн үр дүнд “Философи бол ойлголтуудын түүх мөн” /2.26.43/ гэсэн дүгнэлтэнд Г. Гадамер хүрсэн байдаг.

Философийн уламжлалт ойлголтууд хэлний орчинд хадгалагдахын зэрэгцээ шинэ утга агуулгатай болж хэрэглээнд ордог явдал олонтаа тохиолддог. Философийн ойлголтыг илэрхийлж буй үг нь ярианы хэлтэй салшгүй холбоотой байдаг төдийгүй түүний нөлөөлөлд оршиж байдаг. Энэ утгаараа ярианы хэлэнд философийн ухамсарлагдаагүй үзэл санаа агуулагдаж байдаг ажээ. Иймд философийн ойлголтыг түүний илэрхийлэл болох ярианы хэлний үгтэй хэрхэн холбогдохыг авч үзэх, нөгөөтэйгүүр ярианы хэлний үг философийн ойлголт үүсэхэд хэрхэн нөлөөлснийг шинжлэх нь философийн чухал асуудлын нэг байх ёстой гэдэг санааг үндэслэн “хэлний байнгын дутагдалд философи оршиж байдаг бөгөөд энэ хэрэгцээг нөхөн гүйцээж тэжээгч шим хөрс нь хэлний орчин болдог” /2.38-41/ гэж Г. Гадамер үздэг.

Философийн ойлголтуудыг амьдралтай байнгын холбоотой байлгаж, хийсвэр хөшүүн царцанги байдалд оруулахгүй байх гол арга бол Платоны ярилцлагын хэлбэр байх ёстой ажээ. Иймд “философийн эрхэм зорилго нь ойлголтоор сэтгэх үйл явц, хэлний холбоог сэргээж хэлэнд агуулагдаж байдаг үнэний цогцолбортой түүнийг холбож өгөхөд оршино /2.43/ хэмээн философийн герменевтик үздэг.

Философи бол ганц сэтгэгчийн бясалгал бус, харилцан ярилцлага байх ёстой гэсэн Л.Фейербахын үгээр философийн герменевтикийн баримтлалыг илэрхийлж болох юм. “Бодгалийн ухамсар нь хэлний хүлээсэнд оршиж байдаг бөгөөд энэхүү хэл нь тухайн хүний хэл бус юмс үзэгдэлтэй бидний ярилцдаг хэл байдаг. Хүний амьдрахуйн туршлага, шинжлэх ухаан хоёрын уулзвар болох хэл өнөөгийн философийн гол судлагдахуун болно” /2.25/ гэж Г. Гадамер тэмдэглэсэн байдаг.

Орчин үеийн философи сэтгэлгээнд үлгэр жишээ болохуйц бидний суралцах ёстой гурван суут зөвлөгч ярилцагч нь эртний грекийн философи, Кант, Гегель нар болно гэж Г.Гадамер үзжээ. Грекчууд үг ойлголт хоёрыг сөргүүлэн тавьж байсангүй, сэтгэхүйг ертөнцийн тухай хэлний илэрхийлэлүүдтэй холбоотойгоор авч үзэж ойлголтыг туйлчлах, бүхнийг системд оруулах гэж оролддог догматизмтай тэмцэх үлгэр жишээг бидэнд өгч байна гэж тэрбээр үздэг.

Кантын гол гавьяа нь сэтгэхүй ба танин мэдэхүйн зааг ялгааг тод томруун харуулсанд оршино. Оюун санааны тухай Гегелийн ойлголт нь өнөөгийн философийн анхаарлын төвд буй хэлний үзэгдэл юм. Шинжлэх ухааны эрин үед Гегелээс сурах зүйл байхгүй гэдэг бол төөрөгдөл болно. Аливаа догматизм, түүний дотор шинжлэх ухааны догматизмыг үл таашаах явдал манай зууны оюун санааны нуутдмал буй маш хүчирхэг үндэс мөн гэж би үзэж байна /2.25-26/ хэмээн Г. Гадамер тэмдэглэжээ.

Философийн герменевтикийн үзэл баримтлалын энэ тойм зураглалаас харахад түүнд алдаа онооны аль аль нь

байгаа нь ойлгомжтой юм. Гэвч бид уг сургаалыг магтан сайшаах, үгүйсгэн няцаах туйлшралын нүдээр харахыг зорилго болгосонгүй түүний гол төлөөлөгч Г. Гадамерын бүтээлүүдэд агуулагдаж буй санааг тоймлон гаргахыг хичээсэн болно.

## НОМ ЗҮЙ

1. Гадамер Г. Истина и метод. Основы философской герменевтики. М., 1988.
2. Гадамер Г. Актуальность прекрасного. М., 1991.
3. Герменевтика: история и современность. М., 1985
4. Михайлов А.А. Современная философская герменевтика М., 1984.
5. Лепушкина Е.И. Введение в литературную герменевтику. Санкт-Петербург, 2009
6. Рикер П. Конфликт интерпретации. М., 2008
7. Бетти. Э. Герменевтика как общая методология наук о духе М., 2011
8. Шлейермахер Ф. Герменевтика. М., 2004



### **ABSTRACT**

Issues on correlation between understanding and interpreting are the main source subject of the methodology of hermeneutics. This paper compared the works by Friedrich D.E. Schleiermacher and Hans-Georg Gadamer. F.Schleiermacher considered that a gap between author and interpreter within the process of understanding is needed to be made closer.

Meanwhile, Gadamer's notion of understanding states that it is imperative for new understanding from the dialogues between present and past to be appeared.

Gadamer considers the process of understanding as not only a historical process, but a creative one as well. According to Gadamer, all hermeneutical processes go through three structures: understanding- interpreting- application. Philosophy itself should be the understanding resulting (deriving) from dialogues. As a consequence of understanding, the process of new ideas emergence has foremost importance.